

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Х.ТЭМҮҮЖИН

.....

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр хэлэлцэн баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсгийг “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.” гэж, түүнчлэн Ерөнхийлөгчид тавих насны босгыг өндөрсгөж, зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгогдохоор өөрчлөлт орсон билээ.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт орсноос хойш зургаан жил, Улсын Их Хурлаас Засгийн газарт даалгаснаас хойш дөрвөн жил өнгөрсөн хэдий ч Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэх, дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх ажил орхигдож иржээ.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Монгол Улсын Үндсэн хуулийн 69 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт Үндсэн хуулийн нэгэн адил хүчинтэй байна" заасны дагуу хүчин төгөлдөр Үндсэн хуульд хууль тогтоомжийг нийцүүлэх, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд хийсэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр тодорхойлсон хэрэгцээ шаардлагад үндэслэсэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Ингэхдээ Монгол Улсын Ерөнхийлөгчид Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд тодорхой бүрэн эрхийг олгох үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхтэй холбоотой хуулиудын талаар түүвэр судалгаа хийлээ.

Түүвэр судалгаанаас үзэхэд нийт 71 хуульд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн талаар зохицуулсан байх бөгөөд эдгээрийн 23 хуульд Монгол Улсын Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдоогүй бүрэн эрхийг зохицуулсан, бусад хуульд Монгол Улсын Үндсэн хуульд заасан Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхийн хүрээнд байна гэж үзлээ.

Хуулийн төслөөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуульд заасан үндсэн зарчим, чиг үүрэг, бүрэн эрхийн баталгаа, халдашгүй байдал, үйл ажиллагаанд нь хориглох зүйл, Ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болсны дараах хязгаарлалт зэрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа.

1.Хуулийн төслийн нэгдүгээр бүлэг буюу Нийтлэг үндэслэлд хуулийн төслийн зорилт, Монгол Улсын Ерөнхийлөгчид тавих шаардлага, бүрэн эрхийн хугацааг Үндсэн хуульд нийцүүлэн томъёолж, Ерөнхийлөгчийн бүрэн эрх эхлэх, Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, бүрэн эрх дуусгавар болох, огцруулах үндэслэл, түүний хавсран гүйцэтгэж болохгүй ажил, албан тушаал, гишүүнчлэл, Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж, тэдгээрт тавих шаардлага, хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөр болохтой холбоотой зохицуулалтыг тодорхой хуульчлан тусгав.

Тодруулбал, Ерөнхийлөгчийн Улсын Их Хуралд тангараг өргөх ёслолын ажиллагааг тодорхой хуульчилж, Үндсэн хуульд заасанчлан цэрэг хөдөлгөх шийдвэр гаргах, эсхүл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилуулахаар иргэнийг нэр дэвшүүлэх, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, дэд дарга, зөвлөхийг томилж, чөлөөлөх тохиолдолд захирамж, бусад бүрэн эрхийнхээ хүрээнд зарлиг гаргах, тэдгээрийг хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөр болох хугацааг мөн тодорхой болгов. Түүнчлэн Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх зарлигийн төсөлд Засгийн газраас санал авч, дэмжсэн тохиолдолд зарлигийг гаргах бөгөөд түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болохыг хэвээр үлдээлээ.

Мөн Ерөнхийлөгч улс төрийн намын гишүүн бол Ерөнхийлөгчийн тангараг өргөхөөсөө өмнө намын гишүүнчлэлээ түдгэлзүүлэх, эсхүл гишүүнчлэлээсээ гарах, мөн Ерөнхийлөгч ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээдийн удирдах болон гүйцэтгэх албан тушаал хаших, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн гишүүн байхыг хориглосон зохицуулалтыг тусгав.

2.Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхэд нийцүүлэн тодорхой заалаа.

Ингэхдээ Ерөнхийлөгчийн Улсын Их Хурал, Засгийн газартай харилцах, Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах, гадаад харилцаа, шүүгч, прокурорыг томилох бүрэн эрх, хууль санаачлах, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрт хориг тавих, Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох, гэмт хэрэг үйлдсэн хүнд уучлал үзүүлэх болон бусад бүрэн эрхийн талаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн тодорхой тусгав.

Тухайлбал, Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцаж, үйл ажиллагааныхаа тайланг жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хуралд хүргүүлж, хаврын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулдаг байхаар, гадаад харилцааны талаарх бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдэлж, гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах үүрэгтэй байхаар хуульчиллаа.

Түүнчлэн Ерөнхийлөгч Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах, бүх шатны шүүгч, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох хугацааг тодорхой зааж өгөв.

Ерөнхийлөгч үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлж, ҮАБЗ, түүний ажлын алба бүтцийн хувьд Засгийн газрын системд ажиллах нь Үндсэн хууль болон парламентын засаглалтай олон улсын жишигт нийцсэн оновчтой шийдэл гэж үзэн ҮАБЗ-ийн нарийн бичгийн даргыг тус зөвлөлийг тэргүүний хувьд Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилдог байх, түүнчлэн Зөвлөлийн хуралдааныг Ерөнхий сайдын санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч зарлан хуралдуулах, хэлэлцэх асуудлыг Ерөнхий сайд танилцуулдаг байхаар тусгалаа.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын тухай, Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд нийцүүлэн Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд танилцуулснаар Засгийн газар томилдог байх өөрчлөлтийг тусгалаа.

Ерөнхийлөгчийн гэмт хэрэг үйлдсэн хүнд уучлал үзүүлэхдээ харгалзах шалгуурыг хуульд тусгаж, нөгөөтэйгүүр Эрүүгийн хуульд заасан хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг, болон авлигын гэмт хэрэгт уучлал үзүүлэхгүй байхаар, харин энэхүү уучлал үзүүлэхгүй байх зохицуулалт нь насанд хүрээгүй хүнд хамаарахгүй байхаар тус тус зохицууллаа.

Ерөнхийлөгчийн Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт хориг тавих болон хориг тавихгүй байх үндэслэлүүдийг тодорхойлов. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай хууль, Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж гаргасан шийдвэр, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэж гаргасан шийдвэр, сонгууль товлон зарлаж, санал авах хугацааг тогтоох тухай Улсын Их Хурлын шийдвэр, Улсын Их Хуралд ажлаа хариуцдаг болон Улсын Их Хурлаас томилогддог албан тушаалтныг томилох, чөлөөлөх, огцруулах тухай Улсын Их Хурлын шийдвэр, Улсын Их Хурлын бүрэн эрх, дотоод зохион байгуулалт, дэгийн талаар гаргасан шийдвэр зэрэгт Ерөнхийлөгч хориг тавихгүй байхаар тусгалаа.

3.Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа, халдашгүй байдал, үйл ажиллагаанд нь хориглох зүйлийн талаар тодорхой тусгалаа. Тухайлбал, улс төрийн намын үйл ажиллагаанд оролцох, улс төрийн нам байгуулах, үйл ажиллагааг санхүүжүүлэх, Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд

үл хамаарах асуудлаар бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх, Монголын ард түмний эв нэгдлийг бусниулах, эс үйлдэл, шийдвэр гаргахыг хориглох зэрэг Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд хориглох 11 зүйлийг тусгалаа.

4.Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлэх, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дуусгавар болсны дараа зарим хязгаарлалт, баталгааг шинээр тусгалаа.

Ерөнхийлөгч байсан иргэн Ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болсноос хойш улс төрийн нам байгуулах, эсхүл гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд удирдах болон гүйцэтгэх албан тушаал, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, Улсын Их Хурлын зөвшөөрөлгүй гадаад улсад байнга оршин суух, амьдрахыг хориглохын зэрэгцээ нөгөөтэйгүүр Ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болсны дараа Засгийн газрын гишүүний тухайн үеийн ханштай тэнцэх цалинг насан турш авах, бүрэн эрх дууссанаас хойш 3 жилийн хугацаанд суудлын автомашин болон холбоогоор үйлчлүүлэх, төрийн тусгай хамгаалалтад байх зэрэг баталгаагаар хангагдах зохицуулалтыг тусгасан.

5.Хуулийн төслийн тавдугаар бүлэгт Ерөнхийлөгч үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах Ерөнхийлөгчийн Тамгын газрын эрх зүйн байдлыг тусгав.

Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд холбогдох хуулиар олгох Үндсэн хуулийн үзэл санааг баримтлан Ерөнхийлөгчид бүрэн эрх олгосон хуулиудад судалгаа хийсний үндсэн дээр эдгээр хуулиудын уялдаа холбоог хангах зорилгоор холбогдох хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх үүднээс хуулийн төсөлтэй холбогдуулан Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай, Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Сонгуулийн төв байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай, Монгол Улсын Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль хүчингүй болсонд тооцох

тухай, Улс төрийн албан тушаалтанд тэтгэмж олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг тус тус хийсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр зардал үүсэхгүй тул зардлын тооцоо хийх шаардлагагүй байсан болно.

Хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдийн санал авахаар Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулсан ба Монгол Улсын Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Дээд Шүүх, Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газар, Төрийн албаны зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо, Монголын хуульчдын холбоо зэрэг холбогдох байгууллагууд руу санал авахаар хүргүүлээ.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд бүрэн нийцэж, Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчим, чиг үүргийн дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдэж, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн талаарх холбогдох хуулиудийн зөрчил, хийдэл арилж, уялдаа холбоо хангагдана.

---oOo---